



## НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 9 сарын 07 өдөр

Дугаар 47

Улаанбаатар хот

### Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэн авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, Азийн хөгжлийн банк болон Европын хөрөнгө оруулалтын банкны зээлийн санхүүжилтээр баригдаж ашиглалтад орсон 14,081,049,800.24 (арван дөрвөн тэрбум наян нэгэн сая дөчин есөн мянга найман зуу хорин дөрвөн мөнгө) төгрөгийн өртөг бүхий ус, дулаан дамжуулах төвийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг нэгдүгээр хавсралтаар, иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас нийслэлийн өмчид үнэ төлбөргүй шилжүүлж буй 232,195,887.00 (хоёр зуун гучин хоёр сая нэг зуун ерэн таван мянга найман зуун наян долоо) төгрөгийн инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг хоёрдугаар хавсралтаар тус тус нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.


ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100250


Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн 77 дугаар  
тогтоолын нэгдүгээр хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Ажлын нэр	Нийслэлийн өмчид бүртгэх хөрөнгийн нэр	Ашиг-лалтад орсон он	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	оруулалтын эх үүсвэр	Бүртгэх байгууллага
1	Хан-Уул дүүргийн 5 дугаар хороо, 41-р сургууль, 29, 71 дүгээр цэцэрлэгийг төвлөрсөн халаалтад холбох ажил	Ус дулаан дамжуулах төвийн 1 барилга байгууламж, тоног төхөөрөмж, шугам сүлжээ	2021	454,819,025.00	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	"Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ
		Холигч узель	2021	19,519,723.00		41-р сургууль
		Холигч узель	2021	8,853,260.00		29-р цэцэрлэг
		Холигч узель	2021	8,853,260.00		71-р цэцэрлэг
2	Баянгол дүүргийн 10, 11, 12 дугаар хороо, "Дулааны шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн ажил"	Ус дулаан дамжуулах төвийн 1 барилга байгууламж, тоног төхөөрөмж, шугам сүлжээ	2017	2,525,135,199.00		"Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ
3	Сонгинохайрхан дүүргийн 6, 7, 8, 9 дүгээр хороонд Баянхошуу дэд төв хүртэлх дулааны шинэ шугамын ажил, өргөлтийн насос станц, дулаан дамжуулах төв ЦТП 1, 2 болон 2*160 кВА, 2*250 кВА 2 ширхэг хаалттай дэд өртөө, цахилгаан хангамжийн барилга угсралтын ажил	Ус дулаан дамжуулах төвийн 2 барилга байгууламж, тоног төхөөрөмж, шугам сүлжээ	2021	7,000,014,989.78	Азийн хөгжлийн банкны зээл болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт	"Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ
4	Баянзүрх дүүргийн 19 дүгээр хороонд Шархад дэд төвийн хүрээнд Цайз-Эко хотхоныг инженерийн хангамжийн шугам сүлжээнд холбох барилга угсралтын ажил	Ус дулаан дамжуулах төвийн 1 барилга байгууламж, тоног төхөөрөмж, шугам сүлжээ	2021	2,529,135,477.12	Европын хөрөнгө оруулалтын банкны хөнгөлөлттэй зээл, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт	"Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ
		Цэвэр усны шугам 487м, гадна бохир усны шугам 1185м		1,534,718,866.34		"Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ
<b>Нийслэлийн өмчид бүртгэх хөрөнгийн нийт дүн</b>				<b>14,081,049,800.24</b>		

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн 7 дугаар  
тогтоолын хоёрдугаар хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ШИЛЖИН ИРЖ БУЙ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Байршил	Нийслэлийн өмчид бүртгэх хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Бүртгэх байгууллага
1	Баянгол дүүргийн 18-р хороо, 67А байр	Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж	2020	66,508,000.00	"Амури Оргил" ХХК	"Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ
2	Баянгол дүүргийн 17 дугаар хорооны 47Б байр		2021	61,822,315.00	"Кристал инженеринг констракшн" ХХК	
3	Сонгинохайрхан дүүргийн 18-р хороо, 69 дүгээр байр		2020	40,205,200.00	Иргэн Х.Ихбаяр	
4	Сүхбаатар дүүргийн 3 дугаар хороо, Браухаус цогцолбор байр		2001	49,999,372.00	Браухаус СӨХ	
5	Баянзүрх дүүргийн 5 дугаар хороо, Жуков 1 дүгээр байр		1973	13,661,000.00	Жуков-5 СӨХ	
Нийслэлийн өмчид бүртгэх хөрөнгийн нийт дүн				232,195,887.00		